



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 1/259

Булган сум

Орон нутгийн өмчийн улсын үзлэг,
тооллогын ажлыг зохион
байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.4, 78 дугаар зүйлийн 78.4, Монгол улсын засгийн газрын 2021 оны 278 дугаар тогтоол, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн өмчийн үзлэг, тооллогыг удирдан зохион байгуулах ажлын хэсгийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.
2. Тооллогын ажилд шаардагдах зардлыг 2 дугаар хавсралтаар баталж, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.
3. Орон нутгийн өмчийн үзлэг тооллогын комисс (Т.Баттулга)-т дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай. Үүнд:
 - 3.1. Орон нутгийн өмчийн үзлэг, тооллогын ажлын төлөвлөгөө гарган дүнгийн нэгтгэлийн маягт, зааврын дагуу гаргаж ажиллах.
 - 3.2. Орон нутгийн өмчийн үзлэг, тооллогод хамруулах, хуулийн этгээдийн нэр, тэдгээрийн орон нутгийн өмчийн оролцооны хувь, регистрийн дугаар, улсын бүртгэлийн дугаар, болон бусад холбогдох мэдээллийг мэргэжлийн байгууллагын оролцоотой гаргаж тооллогын ажилд ашиглах.
 - 3.3. Холбогдох шийдвэр, журам, аргачлал, заавар маягыг багтаасан сургалтыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай хамтран аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын тооллогын комиссын гишүүд, алба хаагчдыг хамруулж, зохион байгуулах.
 - 3.4. Орон нутгийн өмчийн үзлэг, тооллогыг хийж гүйцэтгэх, хяналт тавих ажлын хэсгийг томилуулан, ажлын хуваарь боловсруулж, удирдамжаар ханган ажиллах.

6330220313